



Дархан-Уул аймгийн соёл, урлагийн газрын  
2017 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн  
09:11 тутамд албан бичгийн хавсралт

4289366 1922050017 ГСТ7344

## ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БОЛОВСРУУЛСАН ЖУРМУУДЫН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

№	Журмын		Нэмэлт, өөрчлөлт оруулах санал			Тайлбар
	Зүйл, хэсэг, заалтын дугаар	Утга	Нэмэх заалт	Хасах заалт	Өөрчлөх заалт	
<b>Нэг.Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмын төсөл</b>						
1	2.1.4	Төрийн албаны тухай хуулийн 46.1 дэх хэсэг, 62.1.4 дэх заалтад заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн, 62.1.4 дэх заалтад заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц			"Төрийн албаны тухай хуулийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн, 62.1.4 дэх заалтад заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц" гэх	-Хуулийн зүйл, заалтын утгыг тодорхой болгох -Иргэдэд ойлгомжтой байдлаар томьёолох.
2	3.1	Нөөцийн сангийн нэгдсэн бүртгэлийг Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн чиг үүргийг хариуцсан нэгж (цаашид "Төрийн албаны зөвлөлийн нэгж" гэх) хариуцах ба тус нэгж <u>энэ</u> журмын 2.1.2, 2.1.3, 2.1.6-д заасан нөөцийн сангийн бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим систем (цаашид "цахим систем" гэх)-д хөтөлнө.			Нөөцийн сангийн нэгдсэн бүртгэлийг Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн чиг үүргийг хариуцсан нэгж (цаашид "Төрийн албаны зөвлөлийн нэгж" гэх) хариуцах ба тус нэгж <u>энэ</u> журмын 2.1.2, 2.1.3, 2.1.6-д заасан нөөцийн сангийн бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим систем (цаашид "цахим систем" гэх)-д хөтөлнө.	Найруулгын хувьд өөрчлөлт оруулах.
3	3.5	Журмын 2.1.5-д заасан нөөцийн санг төрийн жинхэнэ албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор хөтлөх ба гэр бүлийн гишүүнийг томилтоор ажиллуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан магадлан итгэмжлэгдсэн, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлгийн дүгнэлт зэрэг нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ.			Журмын 2.1.5-д заасан нөөцийн санг төрийн жинхэнэ албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор хөтлөх ба гэр бүлийн гишүүнийг томилтоор ажиллуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан магадлан итгэмжлэгдсэн, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлгийн дүгнэлт зэрэг нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ.	Эрүүл мэндийн тухай хуулийн зүйл, заалтад нийцүүлэх.

		мэргэшлийн эмнэлгийн дүгнэлт зэрэг нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ.			
4	3.6	Байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь төрийн жинхэнэ албан хаагчийг нөөцөд байгаад тооцох үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөхдөө шийдвэр гаргахдаа нөөцийн сангийн зохих бүрэлдэхүүнд бүртгэх заалтыг заавал тусгана.		Байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь төрийн жинхэнэ албан хаагчийг нөөцөд байгаад тооцох үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөхдөө шийдвэр гаргасан тохиолдолд тухай бүр нь хүний нөөцийн мэдээллийн сангийн зохих бүрэлдэхүүнд бүртгэх заалтыг заавал тусгана.	Үйлдлийн хувьд эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож өгөх нь зүйтэй.
5	3.7	Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч нь тухайн албан хаагчийн нөөцийн сангийн бүртгэлд хамаарах хууль эрх зүйн үндэслэлээр чөлөөлөгдсөнийг нотлох шийдвэр, Төрийн албаны тухай хуулийн 46.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн бол эрх бүхий байгууллагын албан бичиг, бусад нотлох баримтыг хавсарган нөөцийн санд бүртгэнэ.		Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч нь тухайн албан хаагчийн нөөцийн сангийн бүртгэлд хамаарах үндэслэлээр чөлөөлөгдсөнийг нотлох шийдвэр, Төрийн албаны тухай хуулийн 46.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр түр чөлөөлөгдсөн бол эрх бүхий байгууллагын албан бичиг, бусад нотлох баримтыг хавсарган нөөцийн санд бүртгэнэ.	Хуулийн зүйл, заалттай нийцүүлсэн.
6	6.2.	Журмын 6.1-т зааснаар эрх нь зөрчигдсөн иргэний мэдээллийг нөөцийн санд нөхөн бүртгэх асуудлыг Төрийн албаны зөвлөлийн үүрэг болгосноор харьялах байгууллагын удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч хэрэгжүүлнэ.		Журмын 6.1-т зааснаар эрх нь зөрчигдсөн иргэний мэдээллийг нөөцийн санд нөхөн бүртгэх асуудлыг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн үүрэг болгосноор харьялах байгууллагын удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч хэрэгжүүлнэ.	Аймаг, орон нутгийн хувьд салбар зөвлөлөөр дамжуулан үүрэг чиглэл авч, биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж хэрэгжилтийг хангуулан ажилладаг.
7	6.5.	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээж, төрийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн, огцорсон иргэнийг нөөцийн санд бүртгэхгүй.		Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хуульд заасан үндэслэлээр хариуцлага хүлээж, төрийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн иргэнийг нөөцийн санд бүртгэхгүй.	Төрийн албан хаагчийг төрийн албанаас халах, чөлөөлөх асуудлыг хуулиар зохицуулсан байдаг.

**Хоёр. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмын төсөл**

1	1.3	Төрийн захиргааны албан тушаалд томилогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор тангараг өргөнө.		Хасах саналтай.		Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолыг ТАЗ, түүний салбар зөвлөл зохион байгуулах саналыг оруулсан.
2	2.2	Төрийн захиргааны тэргүүн түшмэлээс бусад ангиллын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг тангараг өргөх албан хаагч (цаашид "Тангараг өргөгч")-ийг томилсон албан тушаалтан зохион байгуулна.			Төрийн захиргааны тэргүүн түшмэлээс бусад ангиллын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл зохион байгуулна.	Төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг нэгдсэн байдлаар нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд ёс төртэйгээр өргүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
3	2.4	Байгууллагын захиргаа, удирдлагын асуудал эрхэлсэн нэгж нь тангараг өргөх тухайн ёслолын ажиллагааны бэлтгэлийг журамд заасны дагуу хангана.			Тангараг өргөх тухайн ёслолын ажиллагааны бэлтгэлийг энэ журмын 2.1, 2.2-т заасан тангараг өргүүлэх байгууллага хангана.	Тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах субъектэд өөрчлөлт оруулах санал өгсөн болно.
4	5.2	Хэрэв энэ журмын 2.1, 2.2-т заасан албан тушаалтан 1.3-т заасан хугацаанд үүргээ үл биелүүлэн иргэнийг тангараг өргүүлээгүй бол уг албан тушаалтныг чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэн түүнд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.			Тангараг өргөх албан хаагчийг томилсон албан тушаалтан иргэнийг тангараг өргүүлээгүй бол уг албан тушаалтныг чиг үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэн түүнд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.	Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, түүний үйлдэл, эс үйлдэхүйг хариуцлагажуулах нь зүйтэй гэж үзэж байна.

**Гурав. Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах журмын төсөл**

-	-	-	-	-	-	-
Дөрөв. Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын төсөл	-	-	-	-	-	-

САНАЛ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА.....

С.ТУЯА